# БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ



**2023 оны 05 дүгээр сарын 01-ны өдрөөс 05 дүгээр сарын 14-ний хооронд хийгдсэн ажлуудаас**

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдөр автотехникийн улсын үзлэг явагдсан байна.
2. 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Малын тоо толгойд ногдох албан татварыг орон нутгийн хөгжлийн сангийн журмаар зохицуулах нь" сэдэвт чадавхижуулах сургалтыг аймгийн ТАТ-3 нэгжээс зохион байгууллаа. Сургалтанд сумын ИТХ-ын төлөөлөгчид, Засаг дарга, Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд, Багийн Засаг дарга гэсэн албан тушаалтнууд хамрагдлаа.













# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр сумын удирдлагууд засвар хийгдээгүй 5 давхар байрнуудын орц эзэмшигчдтэй уулзаж товч Төрийн бодлого шийдвэр авч хэрэгжүүлж багаа ажлын талаар танилцуулга хийж харилцан ярилцлаа.
2. 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 154-р байрны дээвэр хуурсан байсныг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас мэргэжилтэн авчирч дүгнэлт гаргуулахаар болов.
3. 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 1-р БИНХурал хийж, 2024 онд орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг иргэдээс авч эрэмбэлсэн байна.
4. Мал эмнэлэгийн “Хилийн дэлгэрэх” ХХК-нь 9000 бог малд цэцэг өвчний вакцин хийхээс өнөөдрийн байдлаар 370км явж 12 өрхийн 7104 малыг вакцинжуулалтад хамруулсан байна.








# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар:

- **1. Ирсэн албан бичиг -29**
- -Үүнээс: Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -7
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -3
- Хугацаа хоцорсон -1
- Хугацаа болоогүй-3
- **2. Явуулсан албан бичиг-36**

**3. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**

**1. Засаг даргад ирсэн өргөдөл-1**

- -Шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл-1
- 1. Зоорийг эзэмших хүсэлт-1 /шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн/
- **2. Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл-0**

- **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

-Эзэмшил газраа шилжүүлэхийг хүссэн 2 газрын өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрээ гэрчилгээг гарган өгч ажилласан.
1 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.
1 иргэний өмчлөлийн материалыг хүлээлгэн өгсөн.
2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 13 дугаар хуралдаанаар нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн зориулалтаар нийт 6.72 га талбай, Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг өөрчлөх талаар хэлэлцүүлэн батлуулсан.









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/25 тоот Захирамжаар байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсэг нь 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдөр сумын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг баримтжуулан авч зөрчил арилгах хугацаа өгч хяналт шалгалтыг тогтмолжуулан улирал бүр явуулж байхаар болсон байна.

2. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хуралдлаа. Хурлаар "Хүн бүр байгаль хамгаалагч" нэгдсэн арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цэргийн ангийн хойд хэсэгт сэг зэм, хог хаяж байгаль орчин бохирдуулж байгааг таслан зогсоохоор хяналтын камерийн асуудлыг ярилцаж шийдвэрлэлээ. Орчноо 360 хянадаг 1 камерийг ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа "Хяналтын камер" ажлын хүрээнд цэргийн ангийн хойд хэсэгт байршуулахаар боллоо.








# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- 1. Хил залгаа Сүмбэр сумын нутаг дэвсгэр болох Лүн овооны зүүн урд хилийн цэгээс 100 орчим метрийн зайд байрлах газар малын "Цэцэг өвчин" гарсантай холбогдуулан Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/43 тоот Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай захирамж гарсан.
- 2. 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/44 тоот Хяналтын цэг байгуулах тухай захирамж гарсанаар сумын Онцгой комисс хуралдаж хяналтын пост гарган ажиллуулж байна. Пост лүн овооны хойно байрлах бөгөөд 2 хүний бүрэлдэхүүнтэй үүрэг гүйцэтгэж байна.
- 3. 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр “Хүн бүр байгаль хамгаалагч" нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж Аж ахуйн нэгж байгууллагууд болон оршин суугч иргэд ойр орчмын хуваарьт газрыг цэвэрлэж 6 м куб хог цуглуулан нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн зайлууллаа.

.








# ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР:

- 10 зээлдэгчийн 198,382,706.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс:
  - 2022 онд олгосон 94,909,670.00 төгрөг
  - 2021 оны 2 зээлдэгчийн 59,415,209.00 төгрөгийн үлдэгдэл / хугацаа хэтэрсэн зээл /
  - 2019 оны 2 зээлдэгчийн 12,647,830.00 төгрөгийн үлдэгдэл / муу зээл /
  - 2015 оны 1 зээлдэгчийн 12,932,475.00 төгрөгийн үлдэгдэл /муу зээл/
  - 2013 оны 4 зээлдэгчийн 18,477,522.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. / муу зээл /

- Хүрсэн түвшин:
- 10 Зээлдэгчийн мэдээлэл Монгол банкинд 100 % холбогдсон.
- 4 зээлдэгчийн 13,791,266 төгрөгийн зээл барагдсан
- Өнөөдрийн байдлаар хоршоо хөгжүүлэх санд 32,479,000.00 / гучин хоёр сая дөрвөн зуун далан есөн / төгрөг төвлөрсөн байна.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

## Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-157
- Амбулаторийн үзлэг -104
- Үүнээс:
- Идэвхитэй хяналт -4
- Өдрийн эмчилгээ-2
- Гэрийн эмчилгээ-4

  Урьдчилан сэргийлэх үзлэг- 45
- 

## Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага -15
- Алсын дуудлага -4
- Төвийн дуудлага -11
- Том хүн -11
- Хүүхэд-4
- Осол гэмтэл-0

## Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-8
- Дотор -8
- Хүүхэд -0
- Халдварт-0

## Лабораторийн үзлэгийн тоо: 79 /давхардсан тоо/

-Сахар холестролийн хэмжээ тодорхойлох түргэвчилсэн оношлуур-21 хүн

-Элэгний В,С вирус тодорхойлох шинжилгээ-14, эрэгтэй 7, эмэгтэй-7, ээрэг-1

-Шээсний ерөнхий шинжилгээ -21

-Цусны ерөнхий шинжилгээ-21 эрэгтэй-8, эмэгтэй-11, хүүхэд-2

-Цагаан хорхойн шинжилгээ хүүхэд-1

Биохими эрэгтэй-1






# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:

1. Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/26 захирамжаар **“Камер шинээр авах, засварлах ажил”**-ын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэгт Лүн багийн иргэний төлөөллийг оруулсан байна.
2. 2023 оны 04 дүгээр сарын 27 ны өдөр “Эко паркийн хашаа шинээр барих ажил”-ын тендэрийг зарлаж, 05 дугаар сарын 05 ны өдрийн $9^{30}$ тендер нээж “Ган жигүүр констракшн” ХХК материал ирүүлсэн боловч Тентерт шалгараагүй. Захиалагч байгууллага буюу сумын Засаг дарга-д үнэлгээнийй хорооны дүгнэлт, тендер дахин зарлах зөвлөмжийг хүргүүлсэн.
3. Ажлын даалгаврыг боловсруулж холбогдох 3 компанид албан тоот хүргүүлсэн.






# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

**Хаваржилтын ерөнхий нөхцөл байдал:**

Энэ хавар өөрийн сумын 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035, гадны отрын 1540 нийт 73575 толгой мал хаваржиж байна. Нийт 29020 мал төллөхөөс 2023.05.12-ний байдлаар 18982 мал төллөн унага 63, тугал 120, хурга 15349, ишиг 3450 толгой нийт 18982 төл хүлээн авсан. Мал төллөлт 65,4 %, төл бойжилт 100 %-тай байна.Сумын аюулгүй нөөцийн өвс дууссан, 12 тн 2 жил өнжсөн тэжээлтэй байна.

**-Отор нүүдэл, зөвшөөрөлгүй нэвтэрсэн өрх, малын тоо:**

Төв аймгийн Баян сумын 1 өрх, Дундговь аймгийн 6 өрхийн болон эзэнгүй нийт 10000 гаруй толгой мал отроор ирж хаваржиж байгаа бөгөөд тус айлуудад бэлчээр нутаг чөлөөлөх тухай сумын Засаг даргын албан мэдэгдэл хүргүүлсэн. Одоогийн байдлаар зөвшөөрөл авсан отрын малчин байхгүй байна.

**-Малын өвчний байдал, тайван эсэх:**

Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.

**-Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ дамжуулж байгаа мэдээлэл**:

Цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлийн мэдээг Баянтал ХААТ дундын групп, багуудын Засаг дарга нар болон багийн цахим хаягаар мэдээллийг тогтмол хүргэж хэвшсэн. Мөн WHAT 3 WORDS апликэйшний талаар малчдад мэдээлэл хүргэсэн.

# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

**ЕБСургууль:**

1. 2023 оны 05 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Боловсролын ерөнхий газрын зөвлөн туслах баг "Сургуулийн менежментийг сайжруулах" ажлын хүрээнд хамтран ажиллаж зөвлөгөө өглөө.
2. ЕБСургууль гаднах гэрэлтэй хаягаа шинэчилж, сургуулийн лого, мөн ерөнхий боловсролын сургууль гэсэн байгууллагын хаягаа хос бичгээр хийлгэж байршуулсан байна.

**Сургуулийн өмнөх боловсрол нь:**

1. 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр эцэг эх, асран хамгаалагч нарт “Замын хөдөлгөөний шинэчлэгдсэн дүрэм”-ыг танилцуулан бага насны хүүхэдтэй хамт замын хөдөлгөөнд зөв оролцох сургалтыг явууллаа. Тус сургалтанд 3 бүлгийн 46 эцэг эх, асран хамгаалагч нар 64,7 хувь хамрагдсан байна.










# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:

1.Соёлын үйлчилгээг иргэдэд ойртуулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Соёлын явуулын үйлчилгээг өрх бүрт хүргэн ажиллаж байна.

Соёлын явуулын үйлчилгээний хүрээнд:

- Номын сангийн үйлчилгээ
- 3D Музейн үйлчилгээ
- Угийн бичгийн сургалт
- Баримтат өвийн судалгаа
- Уламжлалт тоглоом наадгайн судалгаа
- Угийн бичиг хөтөлдөг өрхийн судалгаа

-Ховор номын судалгааг тус тус авч, соёл урлагийн үйл ажиллагааг сурталчлан таниулах 7 төрлийн гарын авлагыг түгээн ажиллаж байна.

-2. Нүүдэлчдийн ахуй, үндэсний өв уламжлалыг таниулах зорилгоор "Их түүхийн жимээр" танин мэдэхүйн өртөөчилсөн явган аялалыг ЕБС-н хүүхэд багачуудын дунд Соёлын төв, Сүлд овоо, Миг онгоцны хөшөө гэсэн маршрутаар зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээнд нийт 101 сурагч оролцсон.

3. 05 дугаар сарын 05-ны өдөр "Үндэсний бичиг үсгийн баяр" -ын хүрээнд

- ЕБС-н 6-9-р ангийн сурагчдын дунд "Алтан хонх" танин мэдэхүйн уралдаан,
- Үндэсний бичгээр хэвлэгдсэн ном хэвлэлийн үзэсгэлэн,
- Үзэсгэлэнг нийт 35 хүн үзсэн байна.










# ТАЛЫН ИЛЧ ОНӨААТҮГазар :

Байгууллагад нийт 6 дуудлага ирсэн бөгөөд үүнд:

-Төсөвт байгууллага-1

-ААНБ-1

-Айл өрх-3 /засвар үйлчилгээний дуудлага/

-Цэвэр усны дуудлага-1

2023 оны 04 дүгээр сарын 28-ний байдлаар борлуулалтын авлага **58,600,000** төгрөг байна. Үйл ажиллагаа хэвийн өвөлжилтийн бэлтгэл ажлууд төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа хийгдэж байна.





МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА В.ГАНТУЯА